

**8-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**  
**“А ХУВИЛБАР”**

Сонгох даалгавар

Хугацаа 80 мин

\*Сонгох даалгавар тус бүр 2 оноо

1. Бүлэг байгууллагуудыг тохирох үүрэгтэй нь зөв холбоорой.
 

I. Эмнэлэг	a. Хэрэгцээг хангах
II. Сургууль	b. Аюулгүй орчин бүрдүүлэх
III. Цагдаа	c. Сурч боловсрох
IV. Худалдааны төв	d. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ.
a. 1d, 2b, 3c, 4a	c. 1d, 2c, 3b, 4a
b. 1b, 2c, 3a, 4d	d. 1d, 2a, 3c, 4a
2. Хүмүүс ажиллаж сурч амьдарч буй аймаг, хот, сум, дүүрэг, баг, хорооны хүмүүс хоорондын харилцаа, нийгмийн бүлэг, байгууллагуудын хүрээг юу гэж нэрлэдэг вэ?
 

a. Орон нутгийн байгууллага	c. Орон нутгийн бүлэг
b. Орон нутгийн орчин	d. Орон нутгийн хүрээ
3. Оюуны соёлд аль нь багтах вэ?
 

a. Мэдлэг, боловсрол	b. Байшин барилга	c. Хөшөө дурсгал	d. Байгалийн үзэсгэлэнт газар
----------------------	-------------------	------------------	-------------------------------
4. Материаллаг соёл аль вэ?
 

a. Баяр наадам	b. Археологийн олдвор	c. Шинжлэх ухаан	d. Дээрх бүгд
----------------	-----------------------	------------------	---------------
5. Эрэлт гэдэг нь.....
 

a. Худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээ	c. Хүмүүсийн өдөр тутмын хэрэгцээ юм
b. Хязгааргүй хэрэгцээ	d. Хүний худалдан авах хүсэл юм.
6. Үйлдвэрлэлийн нөөцийг дурдахдаа хамраалгүй зүйл оруулсан бол аль нь вэ?
 

a. Төр	b. Хөдөлмөр	c. Газар	d. Капитал
--------	-------------	----------	------------
7. Хэм хэмжээг хэрхэн ангилдаг вэ?
 

a. Албан ба хууль дүрэм	c. Сайн ба муу
b. Зан заншил ба шударга ёс	d. Албан ба албан бус
8. Нэгэн хүү ээж, дүү нараа тэжээхийн тулд сургуулиасаа гарч ажил хийх болсон байна. Энд түүний ямар эрх зөрчигдөж байна вэ?
 

a. Сурч боловсрох эрх	c. Эвлэлдэн нэгдэх эрх
b. Халдашгүй чөлөөтэй байх	d. Эрүүл байх эрх
9. Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийн хугацаа хэдэн жил байдаг вэ?
 

a. 3 жил	b. 2 жил	c. 4 жил	d. 5 жил
----------	----------	----------	----------
10. Иргэд Засаг даргаа ямар хугацаатайгаар сонгодог вэ?
 

a. 4 жилд нэг удаа	b. 4жилд 2 удаа	c. 5 жилд нэг удаа
--------------------	-----------------	--------------------
11. Зөрчилдөөн гэж юу вэ?
 

a. Зөрчилдөөн бол хүчирхийлэл юм.	c. Маргааныг хэлнэ
b. Зөрчилдөөн нь талуудын сонирхол, эрх агшийг хөндсөн санал зөрөлдөөн юм.	
12. Зөрчил үүсэхэд биеийн гадаад төрх, биеийн хэлэмж нөлөөлөх үү
 

a. Тийм	b. Үгүй
---------	---------
13. Соёлын хожимдлын жишээ аль нь вэ?
 

a. Уул овоогоо тахих	c. Нутаг усаа хайрлан хамгаалах
----------------------	---------------------------------

- b. Байгаль орчныг бохирдуулах d. Ёс заншлаа сахих
14. Соёлын хожимдлын жишээг дурдахдаа илүүц зүйл өгүүлсэн бол аль нь вэ?  
 a. Байгаль орчинтой зүй бусаар харьцах c. Хүмүүстэй зүй зохистой харилцах  
 b. Шударга бус байдал гаргах d. Авилга хээл хахууль
15. Аль нь үнэн, зөв дүгнэлт вэ?  
 a. Нийлүүлэлт их бол барааны хомсдол бий болно. c. Нийлүүлэлт их бол барааны үнэ өснө  
 b. Эрэлт их бол барааны илүүдэл бий болно. d. Эрэлт их бол бараан хомсдол үүснэ.
16. Дараах өгөгдлүүдийн аль нь худал вэ?  
 a. Эрэлт их бол барааны хомсдол үүснэ. c. Нийлүүлэлт бага бол барааны үнэ өснө.  
 b. Нийлүүлэлт их бол барааны илүүдэл өснө d. Эрэлт их бол барааны хомсдол үүснэ.
17. Хүний эрхийг хамгаалахтай холбоотой дараах он ба үйл явдлыг зөв тохируулаарай.  
 1. 1945 онд a. НҮБ байгуулагдсан  
 2. 1948 онд b. НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан  
 A. 1a, 2b B. 1b, 2a
18. Нийгэм, орон нутгийн болон хүмүүс хоорондын харилцааг зохицуулдаг гол хэм хэмжээ нь .....бөгөөд .....-н гол зорилго бол хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулах явдал юм.  
 a. Хууль b. Дүрэм, журам c. Хэм хэмжээ d. Төрийн байгууллага
19. Хорооны засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлөх, огцруулах санал гаргах эрхтэй субъект аль нь вэ?  
 A. УИХ B. Засгийн газар C. Иргэдийн нийтийн хурал D. Нийслэлийн засаг дарга
20. Хорооны засаг даргыг хэн томилох вэ?  
 a. Дүүргийн засаг дарга b. Аймгийн засаг дарга c. Ерөнхий сайд d. Нийслэлийн засаг дарга
21. Хувь хүний сонирхол ба сайн дурын үйл ажиллагааны хувилбаруудыг харгалзуулан зөвөөр тохируулна уу?

	Хувь хүний онцлог		Сайн дурын ажлын жишээ
1	Олон хүмүүстэй байх дуртай	a	Өөрийн дуртай спортоор хичээллэх
2	Биеийн хөдөлгөөн хийх дуртай	b	Бүх нийтийг хамарсан цэвэрлэгээнд оролцох
3	Байгаль орчинд ээлтэй ажил хийх хүсэлтэй	c	Марк цуглуулагчдын бүлэгт орох

A. 1c 2b 3a B. 1a 2b 3c C. 1c 2a 2b D. 1b 2a 3c

22. Хүнд туслах дуртай хувь хүний онцлогт аль нь хамаарах вэ?  
 a. Марк цуглуулагчдын бүлэгт орох c. Өөрийн чаддаг спортод оролцох  
 b. Өндөр настай хүнд туслах d. Цэцэг мод тарих
23. Өөрийн амьдарч буй орон нутгийн хүн амын талаар мэдээлэл цуглуулахад тохирох аргуудыг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ?  
 a. Баримт материал цуглуулах арга c. Асуулгын арга  
 b. Түүврийн арга d. Лабораторийн арга
24. Дараах соёлын өвүүдийг өгөгдсөн жишээтэй нь зөв холбоорой.  
 1) Соёлын биет өв a. Эх хэл болон аман уламжлал, ардын язгуур урлаг, үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадас  
 2) Соёлын өв b. Эртний дурсгалт газар, хадны зураг, бичээс, уран барилгын цогцолбор  
 3) Соёлын биет бус өв c. Тухайн ард түмний соёл, угсаатан, урлагийн ач холбогдолтой биет болон биет бус үнэт зүйл  
 A. 1a, 2b,3c B. 1c, 2b, 3a C. 1b, 2a, 3c D. 1b, 2c, 3a
25. Соёлын нэвчилтийн жишээг аль нь илэрхийлж байна вэ?  
 a. Төрсөн өдрийн баяр c. Эрийн гурван наадам  
 b. Шинэ жилийн баяр d. Буддын шашин
26. Соёлын хожимдолтыг аль нь илэрхийлж байна вэ?  
 a. Цөлжилт b. Шинэ технологи нээх c. Байгалийн дулаарал d. Байгаль орчинтой зүй бусаар харьцах
27. Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны хэлбэрүүдийг зөв холбоорой.  
 I. Үйлчилгээ A. Төрөл бүрийн бараа худалдан авч хадгалах, тээвэрлэх, худалдах үйл явц

- II. Худалдаа В. Хэрэглэгчдийн хэрэгцээ хангах чадвартай материаллаг биет зүйлс үйлдвэрлэн гаргах ба ном, сурах бичиг, гутал гэх мэт
- III. Үйлдвэрлэл С. Хүмүүсийн хэрэгцээг хангах зорилготой бодит бус шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бөгөөд эдгээр нь үсчин, зурагчин, төрөл бүрийн засвар, зөвлөгөө өгөх
- a. 1a,2b,3c b. 1c,2a,3b c. 1b, 2a, 3c d. 1c,2b,3a
28. Зах зээлийн үндсэн ойлголтуудыг өгөгдсөн жишээтэй нь зөв холбоорой
- I. Зах зээл a. Сурагчийн дэвтэр 1900 төгрөгийн үнэтэй байхад түүний эрэлт болон нийлүүлэлтийн тоо хэмжээ 35000 дээр тэнцвэржсэн үзүүлэлттэй байлаа.
- II. Эрэлт b. Сурагчийн дүрэмт хувцасны үнэ 40% нэмэгдсэн ч хэрэглэгчид худалдан авч, үйлдвэрлэгчид үнэ нэмсэн хэвээр л байлаа
- III. Нийлүүлэлт c. Best color internatioanal хэвлэлийн компани сурах бичиг үйлдвэрлэхээр болов.
- IV. Зах зээлийн тэнцвэрт үнэ d. сурагч Болд төгсөх анги учраас өөрт зайлшгүй хэрэгтэй байсан гарын авлага, төстийн номнуудаа 50000 төгрөгт багтаан худалдан авав.
- A. 1b,2d,3c,4a B. 1b, 2a, 3c,4d C. 1a,2d,3c, 4b D. 1a, 2d, 3c, 4b
29. Талхны эрэлт, нийлүүлэлтэд үндэслэн зах зээлийн тэнцвэрт үнэ тогтсон мөрийг олно уу.
- a. Талхны үнэ, төг-450 Талхны нийлүүлэлт шир.-4500, Талхны эрэлт, шир-6500
- b. Талхны үнэ, төг-550 Талхны нийлүүлэлт шир.-5000, Талхны эрэлт, шир-6000
- c. Талхны үнэ, төг-650 Талхны нийлүүлэлт шир.-5500, Талхны эрэлт, шир-5500
- d. Талхны үнэ, төг-750 Талхны нийлүүлэлт шир.-6000, Талхны эрэлт, шир-5000
30. Эрх эдлэгч, үүрэг хүлээгч гэж хэн бэ? Дараах ойлголтууд ба үүрэг, хариуцлагын хамаарлыг зөв холбоорой.
- I. Эрх эдлэгч a. Бусдын эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ.
- II. Үүрэг хүлээгч b. Хүний эрх зөрчигдөд хариуцлага оногдуулах эрх хэмжээтэй
- A. 1a, 2b B. 1b, 2a
31. Иргэн "Г" ИНХ-д хорооны засаг даргын үйл ажиллагааны талаар өөрийн саналыг хэлэх гэсэн боловч түүнийг үгийг хэлүүлсэнгүй. Энд түүний ямар эрх зөрчигдөж байна вэ?
- A. Үзэл бодлоо илэрхийлэх эрх C. Оролцооны эрх
- B. Эрүүл аюулгүй орчинд амьдрах D. Хамгаалуулах эрх
32. Хүний эрхийг хамгаалах гол арга хэрэгсэл юу вэ?
- A. Төрийн байгууллага B. Хууль C. Иргэн D. Төр
33. Орон нутгийн удирдлагын бүрдэл хэсгийг холбогдох томилгоотой нь зөв холбоно уу
- A. Аймаг нийслэлийн ИТХ a. Баг хорооны засаг дарга
- B. Сум дүүргийн ИТХ b. Сум дүүргийн засаг дарга
- C. Баг хорооны ИТХ c. Аймаг нийслэлийн засаг дарга
- a. 1a, 2b, 3c b. 1b, 2c, 3a c. 1c, 2b, 3a d. 1c, 2b, 3a
34. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг тохирох өгөгдөлтэй нь зөв холбоорой.
- I. Хэрэгжүүлэгч a. Дөрвөн жил
- II. Эрх мэдлийн эх сурвалж b. Хуралдаан
- III. Ажиллах хэлбэр c. Иргэдийн хурлаар болон сонгуулиар сонгогдох
- IV. Хугацаа d. ИНХ, ИТХ
- a. 1a, 2b, 3c, 4d c. 1b, 2d, 3c, 4a
- b. 1b, 2c, 3d, 4a d. 1d, 2c, 3b, 4a
35. Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн зөв тодорхойлолт аль нь вэ?
- a. Орон нутагт хүүхдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд насанд хүрэгчдэд нөлөөлж хамтран ажилладаг сонгуульт байгууллага юм.
- b. Орон нутагт шийдвэр гаргах түвшний байгууллага юм.
- c. Орон нутгийн түвшинд асуудлыг шийдвэрлэдэг байгууллага юм.

### ЗАДГАЙ ДААЛГАВАР

36. Танай орон нутгийн хүмүүсийн амьдралын дараах хэрэгцээг ямар байгууллага, бүлгүүд хангадаг вэ? Нэрлэж бичээрэй.
- /6 оноо/
- Жишээ нь: Сурч, боловсрох хэрэгцээ- Цэцэрлэг гэх мэт
- A. Мөнгө санхүүгийн хэрэгцээ-.....

- B. Сурч, боловсрох хэрэгцээ-.....
- C. Аюулгүй байдлын хэрэгцээ-.....
- D. Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ-.....
- E. Бие физиологийн хэрэгцээ-.....
- F. Хүндлэл хүлээх хэрэгцээ-.....

37. ....2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр тус чуулганаар "Уул овоо тахих Монгол зан үйл"-ийг ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэжээ. Энэхүү зан үйл нь манай улсаас дэлхийд данстай болж буй 14 дэх соёлын биет бус өв юм. /6 оноо/

- a. Уул овоогоо тахиж буй учир шалтгаан нь юу вэ?
- b. Уул овоо тахих зан үйлийг дагалдан гардаг сөрөг үр дагаварууд\хог хаях, байгаль орчин бохирдуулах ..гэх мэт\ыг арилгахын тулд ямар зохицуулалт хийх ёстой вэ?
- c. Байгаль дэлхий, уул усаа хайрлаж хамгаалахтай холбогдсон хорио цээр хэллэгүүд байдаг. Нэрлэж бичнэ үү.
- d. Уламжлалт зан үйл, ёс заншлаа дагаж мөрдөхийн ач холбогдол нь юу вэ?
- e. Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах талаар өөрийн саналыг бичнэ үү.

38. Сурагч Б-ийн гэр бүлийн гишүүд хамтран өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор жижиг үйлдвэрлэл эрхлэхээр болжээ. Тэд зах зээлийн эрэлт болон өөрсдөд байгаа мөнгөний боломждоо тулгуурлан нэгэн жижиг байр түрээслэн “Амуу” нэрийн боов үйлдвэрлэх болов. Тэд өдөрт 80 ширхэг, сард 2400 ширхэгийг үйлдвэрлэж, ширхэгийг нь 900 төгрөгөөр борлуулах юм. Хүснэгтэд өгөгдсөн мэдээллийг ашиглан Амарбаясгалангийн гэр бүлийн ашиг орлогыг тооцоолно уу. /6 оноо/

Эдийн засгийн үзүүлэлтүүд /сараар/		
№	Үзүүлэлтийн төрөл	Мян.төг
1	Түрээсийн зардал	200,0
2	Хөдөлмөрийн хөлс	800,0
3	Түүхий эд	310,0
4	Сав баглаа боодол	50,0
5	Цахилгаан	25,0
6	Тээврийн хөлс	30,0
7	Бусад зардал	80,0

- a. Бизнес эрхлэх болсноор орон нутагт ямар хувь нэмэртэй вэ?
- b. Б-ийн гэр бүлийн үйлдвэрлэлийн нийт зардлыг тооцож бодно уу
- c. Гэр бүлийн үйлдвэрлэлийн сарын нийт орлогыг олно уу.

39. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүргийг тодорхойлон бичнэ үү. /6 оноо/

- a. Хүндэтгэх үүрэг:  
.....
- б. Хангах үүрэг:  
.....
- в. Хамгаалах үүрэг:  
.....
- г. Ахиц дэвшил гаргах үүрэг:  
.....

40. Орон нутгийн удирдагч нь нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулан хэрэгжүүлдэг билээ. Орон нутгийн удирдагчын чиг үүргийг гүйцээж нөхнө үү. /6 оноо/

Орон нутгийн удирдлага		
Ялгаа:	1.....	Төрийн удирдлага
Хэрэгжүүлэгч:	2.....	Засаг дарга
Эрх мэдлийн эх сурвалж	3.....	Дээд шатны засаг дарга томилох
Ажиллах хэлбэр.	Хуралдаан	4.....
Хугацаа:	5.....	6.....